



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалын хугацаа
сунгах, үнийг шинэчлэн тогтоох
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар, нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох нийт 715 нэрийн 3,036,103,421.49 (гурван тэрбум гучин зургаан сая нэг зуун гурван мянга дөрвөн зуун хорин нэгэн төгрөг дөчин есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадралд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ



0000187

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
 2020 оны 03 сарын 10-ний өдрийн
 59 дугаар тогтоолын хавсралт

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, ХАРЬЯА АЛБА, НЭГЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
 ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ЖАГСААЛТ**

Д/д	Байгууллагын нэр	Хөрөнгийн дансны ангилал	Нийт нэр төрөл	Тоо хэмжээ	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа
1	Төв аймгийн Онцгой байдлын газар	Тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, Тавилга эд хогшил	140	212	773,417,293.48	218,362,000.00	1-10 жил
2	Шатахууны нөөцийн салбар	машин тоног төхөөрөмж, Тавилга эд хогшил, Биет бус хөрөнгө (Програм хангамж)	21	27	39,186,006.53	16,995,000.00	2-3 жил
3	Хүнсний нөөцийн салбар	Тавилга эд хогшил	20	25	10,262,318.94	4,599,258.00	3-4 жил
4	ОБЕГ-ын харьяа Улсын нөөцийн Объект-03	Тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, Тавилга эд хогшил	10	414	65,629,920.00	13,600,000.00	2 жил
6	Увс аймгийн Онцгой байдлын газар	Машин тоног төхөөрөмж, Тавилга эд хогшил, Биет бус хөрөнгө (Програм хангамж)	110	146	134,182,163.42	44,285,700.72	2-4 жил

Д/д	Байгууллагын нэр	Хөрөнгийн дансны ангилал	Нийт нэр төрөл	Тоо хэмжээ	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа
7	Ховд аймгийн Онцгой байдлын газар	Машин тоног төхөөрөмж, Тавилга эд хогшил, тээврийн хэрэгсэл	100	235	889,426,008.15	71,322,678.59	2-3 жил
8	Аврагч биеийн тамир техник, спортын хороо	Машин тоног төхөөрөмж, Тавилга эд хогшил	28	107	28,206,500.00	9,874,000.00	2-3 жил
9	Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар	Машин тоног төхөөрөмж, Тавилга эд хогшил, тээврийн хэрэгсэл	62	98	562,753,534.39	75,970,000.00	2-4 жил
	Давтан сургалт, сэргээн заслын төв	Тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, Тавилга эд хогшил	224	793	533,039,676.58	100,329,100.00	2-4 жил
	Дүн		715	2057	3,036,103,421.49	555,337,737.31	
					(гурван тэрбум гучин зургаан сая нэг зуун гурван мянга дөрвөн зуун хорин нэгэн төгрөг дөчин есөн мөнгө)	(таван зуун тавин таван сая гурван зуун гучин долоон мянга долоон зуун гучин долоон төгрөг гучин нэгэн мөнгө)	